

## **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2022 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” /цаашид “журам” гэх/-ын 5 дугаар хэсэгт заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн нэгтгэн дүгнэсэн болно.

Журмын 5.2-т зааснаар Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын нэгж нь 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг цахим системээр хүлээн авч 58 төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаарх дүгнэлт хүргүүллээ.

### ***Худалдан авах ажиллагааны төлөвлөлт:***

Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг журамд заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр хуульд заасан хугацаандаа ирүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааны цахим системд нийт 58 төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд 30,559 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж, хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт зааснаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж ажилласан байна.

Цахим системээр ирүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны 2022 оны тайлангаас үзэхэд нийт 14,611.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 30,559 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Төлөвлөлтийг худалдан авах ажиллагааны журмаар ангилан үзэхэд нийт 11,814.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 7,494 худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт, 2,277.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8,952 худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 395.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,234 худалдан авах ажиллагааг зөвлөх үйлчилгээний журмаар, 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 128 олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 122.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12,751 худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтаар зохион байгуулахаар тус тус төлөвлөсөн байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүснэгт 1. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт (журмаар)

Төлөвлөлт /журмаар/	ТШ-ын тоо	Нийт тоонд эзлэх хувь	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт эзлэх хувь
<b>Нээлттэй тендер шалгаруулалтын журам</b>	7494	25%	11,814,829,783,943	80.86%
<b>Тендер шалгаруулалтын онцгой журам</b>	8952	29%	2,277,504,959,532	15.59%
<b>Зөвлөх гүйцэтгэгчийг үйлчилгээний сонгон шалгаруулах журам</b>	1234	4%	395,363,060,624	2.71%
<b>Шууд худалдан авалт</b>	12751	42%	122,712,723,152	0.84%
<b>Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам</b>	128	0%	1,463,871,061	0.01%
<b>Нийт</b>	<b>30559</b>	<b>100%</b>	<b>14,611,874,398,312</b>	<b>100.00%</b>

Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилд батлагдсан төсөвт үндэслэн хууль, журамд заасны дагуу бүрэн төлөвлөх үүрэгтэй байдаг.

Цахим системийн мэдээллээс үзэхэд 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 57 төсвийн ерөнхийлөн захирагч нийт 12,866 удаа өөрчлөлт оруулсан байх бөгөөд үүнээс хамгийн олон өөрчлөлт оруулсан нь Нийслэлийн Засаг даргын багцын төлөвлөгөөнд 187 удаа, Эрүүл мэндийн сайдын багцын төлөвлөгөөнд 126 удаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын төлөвлөгөөнд 146 удаа, Хууль зүй дотоод хэргийн сайдын багцын төлөвлөгөөнд 90 удаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцын төлөвлөгөөнд 67 удаа, Эрчим хүчний сайдын төлөвлөгөөнд 57 удаа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяа байгууллагуудын төлөвлөгөөнд 38 удаа тус тус өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь төсөвт бөөн дүнгээр батлагдсан төсвийг бүтэн жилийн турш хувааж захирамж, тушаал гарган хэрэгжүүлж байгаа болон захиалагч худалдан авах ажиллагааны цахим системээр эрх шилжүүлэхгүй байх, төлөвлөсөн хугацаандаа худалдан авах ажиллагааг эхлүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Төлөвлөгөөнд жилийн турш нэмэлт өөрчлөлт оруулж байгаа нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдах, улмаар төсвийн жил дамжих, улирлын чанартай ажлын хувьд хэрэгжихгүй байх сөрөг талтай байдаг.


### **Худалдан авах ажиллагааны хэрэгжилт:**

Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг заасан хугацаанд тендер шалгаруулалтыг хэрэгжүүлж, гэрээ байгуулж дууссан байх үүрэгтэй байдаг.

Худалдан авах ажиллагааны цахим систем дэх тоон мэдээлэлд үндэслэн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилтийг дүгнэж байгаа тул цахим системээр зарлагддаггүй шууд худалдан авалтын тоо, төсөвт өртгийн хэмжээг нийт төлөвлөсөн худалдан авах ажиллагааны дүнгээс хасч нийт 17,808 худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг гарган танилцуулж байна.

Улсын хэмжээнд 2022 онд худалдан авах ажиллагааны цахим системээр нийт 17808 тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 12598 тендер шалгаруулалтын урилга нийтлэгдсэн бөгөөд 5210 тендер шалгаруулалт буюу 30 хувийг огт зохион байгуулаагүй байна.

График 1. Тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зарласан байдал




Нийт зарлагдсан тендер шалгаруулалтуудыг төлөвлөсөн хугацаанд зарласан эсэхийг цахим систем дэх мэдээлэлд үндэслэн гаргахад төвлөсөн хугацаандаа зарлагдсан 2,902 тендер шалгаруулалт байгаа бол төлөвлөсөн хугацаанаас хойш зарлагдсан 9,696 тендер шалгаруулалт байна (График 1).

Үүнээс үзэхэд захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг оновчтой төлөвлөдөггүй, батлагдсан төлөвлөгөөнд заасан хугацааг баримталдаггүй байна. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан улирлын чанартай хийгддэг ажлууд хэрэгжих боломжгүй болох, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах нөхцөлийг үүсгэж байгаа гол шалтгаан болж байна.

Тайлант хугацаанд нийт 10,049.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12,598 тендер шалгаруулалт зарласан бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрээр ангилан үзвэл улсын төсвийн хөрөнгөөр 3,752.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 3,039 тендер шалгаруулалт, орон нутгийн төсвөөр 1,342.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 4,264 тендер шалгаруулалт, өөрийн хөрөнгө 4,776.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 4,785 тендер шалгаруулалт, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 56.0 тэрбум төгрөгийн өртөгтэй 107 тендер шалгаруулалт, хамтран санхүүжилт болон бусад сангийн хөрөнгөөр нийт 122.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 403 тендер шалгаруулалт тус тус зохион байгуулсан гэж тайлагнасан байна (хүснэгт 2).

График 2. Санхүүжилтийн эх үүсвэр



Зурагт үзүүлснээр, өөрийн хөрөнгөөр худалдан авалт хийдэг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын худалдан авалт улсын хэмжээний нийт худалдан авалтын 48 хувийг эзэлж байгаа бол улсын төсөв 37 хувь, орон нутгийн төсөв 13 хувь байна (Хүснэгт 3).

Хүснэгт 2. Санхүүжилтийн эх үүсвэр

Санхүүжилтийн эх үүсвэр	Тендер Шалгаруулалтын тоо	Төсөвт өртөг /тэрбум төгрөг/
<b>Өөрийн хөрөнгө</b>	4785	4,776.49
<b>Улсын төсөв</b>	3039	3,752.34
<b>Орон нутгийн төсөв</b>	4264	1,342.55
<b>Сан болон бусад</b>	403	122.22
<b>Гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт</b>	107	56.01
<b>Нийт</b>	<b>12598</b>	<b>10,049,6</b>

Худалдан авах ажиллагааны цахим систем дэх тоон мэдээллээс худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлсэн байдлыг дүгнэж үзэхэд 9,362.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 6,016 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 463.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5,704 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 223.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 871 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээний журмаар, 133.9 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар хэрэгжүүлсэн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 3. 2022 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилт (журмаар).

Журмын нэр	Зарласан ТШ-ын тоо	Нийт дүнд эзлэх хувь	Төсөвт өртөг /төг/	Төсөвт өртөгт эзлэх%
Нээлттэй тендер шалгаруулалтын журам	6016	47.75%	9,362,596,127,026	93.16%
Тендер шалгаруулалтын онцгой журам	5704	45.28%	463,653,605,021	4.61%
Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	871	6.91%	223,225,311,904	2.22%
Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам	7	0.06%	133,889,500	0.00%
<b>Нийт</b>	<b>12598</b>	<b>100.00%</b>	<b>10,049,608,933,451</b>	<b>100.00%</b>

Нийт худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийг төсөвт өртөгтэй харьцуулахад 93.1 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу, 4.6 хувь нь тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу зохион байгуулсан байна. Үүнээс үзэхэд 2022 оны худалдан авах ажиллагаа нь хуульд заасан үндсэн зарчмын дагуу зохион байгуулагдсан байна.

**Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал:**

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлахаар хуульчилсан. Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Тайлант хугацаанд 11.2 тэрбум төгрөгийн өртөгтэй 15 худалдан авах ажиллагааг уламжлалт буюу цаасан хэлбэрээр зохион байгуулсан бол нийт 10,038.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12,583 тендер шалгаруулалт буюу 99.9 хувийг цахим системээр зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт сүүлийн 4 жилийн турш 98 хувиас дээш өсөж 2022 онд 100 хувьд хүрээдбайна.

Түүнчлэн Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу 583.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 184 төсөл арга хэмжээ, Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу 108.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 205 төсөл арга хэмжээ, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны журмын дагуу 20.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээний урилгыг цахим системээр дамжуулан зарласан байна.

Тайлант хугацаанд захиалагч цахим системээр давхардсан тоогоор 24,573 урилга нийтэлсэн байгаа бол 23,457 мэдэгдэл нийтэлсэн байна. (Хүснэгт 5.)

Хүснэгт 4. Цахим системийн ашиглалт

Журмын нэр	Урилга нийтэлсэн	Мэдэгдэл хүргүүлсэн	Урилга/Мэдэгдэл -ийн харьцаа	Үр дүн нийтэлсэн	Урилга/Үр дүнгийн харьцаа
<b>ЗҮГСШЖ</b>	2,480	1,210	49%	2,198	89%
<b>НТШ</b>	9,453	6,087	64%	9,099	96%
<b>ОНОХААЖ</b>	9		0%	8	89%
<b>ТШОЖ</b>	12,631	6,316	50%	12,152	96%
<b>БҮГД</b>	24,573	13,613	55%	23,457	95%

Дээрх хүснэгтээс харахад тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд 95 хувьтай нийтэлсэн байх бөгөөд гэрээ байгуулах эрх олгогдсон тендер оролцогчийн тендерийг бусад оролцогч нарт журамд заасны дагуу ил болгосон байна.


Харин захиалагч нийт 24,573 урилгын дагуу нийт 13,613 мэдэгдэл хүргүүлсэн байна. Цахим систем дэх тоонд үндэслэн мэдэгдэлийг тендер хүчинтэй байх хугацаанд нийтэлсэн эсэхийг хянан үзэхэд 12,400 нь хугацаандаа нийтэлсэн бол 1,213 нь хугацаа өнгөрсөнөөс хойш нийтэлсэн байна.

***Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдлын шийдвэрлэгдсэн байдал:***

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйлд тендер оролцогчдоос тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг гаргахдаа аль шатанд ямар байгууллагад хандахыг тодорхой зааж өгсөн байдаг.

Тайлант хугацаанд тендер шалгаруулалттай холбоотойгоор гомдлыг холбогдох байгууллагуудад нийт 1,548 гомдол гаргасан байна. Тендер шалгаруулалттай холбоотой 2022 онд гарсан гомдол нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд 184, захиалагчийн шийдвэрт 1,299, гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд 65 гомдол тус тус хандсан байна. (График 3.)

График 3. Тендер шалгаруулалттай холбогдуулан гарч буй гомдлын тоо /байгууллагаар/




Тайлант хугацаанд нийт гомдлын 80 хувь нь захиалагчийн шийдвэрт гомдол гаргасан байгаа бол 15 хувь нь нээлт хийхээс өмнөх шатанд, 5 хувь нь шүүхэд хандан гаргасан байна. Шүүхэд хандсан гомдлын тоо өмнөх онтой харьцуулбал 7 хувиар буурсан байна.

Сангийн яаманд тендерт оролцогч тендерийн баталгаагаа барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах хуулийн зохицуулалтын дагуу 2022 онд 40 үндэслэлгүй гомдолд барьцаалсан 303,512,309.08 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгох шийдвэр гаргаж, Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгдөг.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 740 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 55 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна (График 4.)

График 4. Сангийн яаманд ирсэн гомдлын шийдвэрлэлт



Тайлант хугацаанд тендерт оролцогчдоос захиалагчийн шийдвэртэй санал нийлэхгүй үндэслэлээр Сангийн яаманд нийт 1299 гомдлыг ирүүлсэн.

Тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын 61 хувь нь үндэслэлтэй байна.

	2018	2019*	2020	2021	2022
<b>Нийт тендер шалгаруулалт</b>	5,694	13,837	22,598	22,334	25349
<b>Гомдол</b>	<b>1,187</b>	<b>1,060</b>	<b>1,009</b>	<b>870</b>	<b>1299</b>
<b>Хувь</b>	21%	8%	4%	4%	5%
<b>Үндэслэлтэй гомдол</b>	639	572	590	550	795
	54%	54%	58%	63%	61%
<b>Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалт</b>					
<b>Гомдол</b>	151	55	44	44	99
<b>Хувь</b>	14.2%	5.4%	5.4%	8.0%	7.6%

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Цаашид захиалагч хуулийн 46 дугаар зүйлд заасан үүргийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Гомдол шийдвэрлэлтийн бусад төрөлд Сангийн яам гомдол гаргах хугацаанд тус яаманд хандаагүй, захиалагч байгууллага гэрээ байгуулсан, эсхүл гаргасан гомдлыг эргүүлэн татсан шийдвэрүүдийг багтаасан. Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол



гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.” гэж заасны дагуу буцаасан болон шүүхэд хандах 268 гомдол, гаргасан гомдлыг эргүүлэн татсан 50, захиалагчид гомдол гаргах 12 гомдол байсан болно.

### ***Худалдан авах ажиллагааны сургалтын талаар:***

Хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны гишүүдэд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. 2022 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтын шалгалтад 9,905 суралцагч бүртгүүлж, 775 удаагийн шалгалтад 5,215 суралцагч тэнцэж нийт гэрчилгээ эзэмшигчдийн тоо 12,738 болсон.

Хуулиар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөл, орон нутагт иргэнийг оролцуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулах зохицуулалтыг тусгасан байдаг.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан үнэлгээний хорооны гишүүнээр олон давтамжтайгаар ажиллах нь тухайн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлаж, сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй байна. Нөгөө талаас үнэлгээний хорооны хуралд оролцохгүйгээр гарын үсэг зурах зөрчил нийтлэг байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг цаасаар олгохыг зогсоож зөвхөн цахим систем [/www.tender.gov.mn/mn/exam/certificate/](http://www.tender.gov.mn/mn/exam/certificate/)-ээр дамжуулан шалгалтад тэнцсэн тухайн өдрөө гэрчилгээг гардан авах боломжтой болсон. Гэрчилгээг системээр дамжуулан олгох нь Төрийн худалдан авах ажиллагааны газар болон гэрчилгээ авахаар ирдэг иргэдийн зардал, ачааллыг бууруулж байгаа давуу талтай байна.

Түүнчлэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт үнэлгээний хороонд орж ажиллах иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах ажлын хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Цахим сургалтын систем [/www.surgalt.tender.gov.mn/](http://www.surgalt.tender.gov.mn/)-ийг ашиглалтад оруулан, сургалтыг зохион байгуулж байна.

Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан ажилтнууд давтан танхимын сургалтад хамрагдалгүйгээр хугацааг сунгах боломжийг олгосон.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим сургалтын систем [/surgalt.tender.gov.mn/](http://surgalt.tender.gov.mn/)-ээр бие даан, үнэ төлбөргүйгээр хичээл үзсэн 324 хүнээс 52 удаагийн цахим шалгалт авсан бөгөөд 247 суралцагч шалгалтад тэнцсэн.

### ***Ерөнхий гэрээний хэрэгжилтийн талаар:***

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.23, 53 дугаар зүйлийн 53.5.7 дахь заалтад заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газраас ерөнхий гэрээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, холбогдох мэдээллийг цахим дэлгүүрийн системд байршуулсан.

Тайлант хугацаанд ерөнхий гэрээний 18 тендер шалгаруулалт зохион байгуулж, шинээр 214 нэр, төрлийн бараа үйлчилгээг ерөнхий гэрээнд оруулж, цахим дэлгүүрт бүртгэсэн бөгөөд үүний 107 бараа, үйлчилгээ нь дотоодын үйлдвэрлэгч байна.

Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс 2022 онд хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах 990 захиалагч байгууллагаас 213 нэр төрлийн бараа, үйлчилгээг 101,3 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна.

Ерөнхий гэрээ нэгж үнийн дээд хязгаараас хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын дагуу худалдан авсан нийт үнэ буюу 14.7 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээнээс хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын дагуу хамгийн их хэмжээгээр худалдан авсан 15 нэр төрлийн барааг дараах хүснэгтээр үзүүлж байна.

**Ерөнхий гэрээний дагуу худалдан авсан барааны дүн  
/захиалгын дүнгээр - эхний 15/**

№	Бараа, үйлчилгээний нэр	Захиалгын тоо	Захиалгын дүн	Хэмнэлт
1	Таблет /Android 32GB/	16,281	14,636,592,000	16,308,000
2	Зөөврийн компьютер /i5/	1,532	4,387,994,200	208,005,800
3	Боловсролын сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын цогц систем /School & Learning Management System/	3,175,758	4,320,888,487	2,030,627,513
4	Таблет /Android 64GB/	2,449	3,915,951,000	2,449,000
5	Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ширээ сандлын иж бүрдэл /ширээ-1; сандал-2/	7,185	3,628,425,000	-
6	Натрийн хлорид 0.9%-100мл	2,579,470	3,212,019,194	12,318,306
7	Альбумин 20%-100мл	14,342	2,903,125,190	395,534,810
8	Суурин компьютер /i5/	936	2,894,380,170	194,419,830
9	Ухаалаг самбар 65"	292	2,882,662,000	8,138,000
10	Суурин компьютер /i7/	721	2,809,326,150	74,673,850
11	Гөлгөр шар цаастай, оёотой, 84x108/16 форматын сурах бичиг хэвлэх нийлүүлэх	92,524,568	2,616,889,156	379,056,356
12	Зөөврийн компьютер /i7/	569	2,212,633,160	120,266,840

13	Гөлгөр шар цаастай, оёотой, 70x100/16 форматын сурах бичиг хэвлэн нийлүүлэх	87,498,000	2,162,266,260	623,670,060
14	nCoV-2 ПГУ оношлуур дагалдах хэрэгслийн хамт /бамбар, орчин, ПГУ тюрб/	186,574	2,051,893,520	744,850,740
15	Зөөврийн компьютер /i3/	936	2,023,091,420	129,708,580

### ***Төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланд өгсөн нэгдсэн дүгнэлт:***

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах дүгнэлтийг хүргүүлж байна. Үүнд:

1.Цахим системд 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт худалдан авах ажиллагааны 30 хувь буюу 5210 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, нийт төлөвлөсөн худалдан авах ажиллагааны 9,696 буюу 77 хувь нь төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй байгаа нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт бодитой бус, төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажилладаггүй, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг олноор төлөвлөж байгаа нь худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэхэд хугацаа алдах, төлөвлөлт, гүйцэтгэл зөрөх үндсэн шалтгаан болж байна;

2.Цахим системд 2022 онд 24,573 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлснээс 23,457 тендер шалгаруулалтын үр дүн нийтэлсэн ба хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг зөрчиж тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нийтлэхгүй байх, хугацаа хоцроох буюу жилийн төгсгөлд мэдээлж байна;

3.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр ирүүлдэггүй;

4.Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 61 хувь нь захиалагч хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журмыг зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа нь захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй;

5.Улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулахгүй байгаа нийтлэг зөрчил нь хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.